



ДААТГАЛ
SINCE 1994

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

MSE:  IC

Агуулга

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

Хурлаар хэлэлцэх асуудал

1. 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан
2. 2021 онд олгосон ногдол ашгийн тайлан
3. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 65 дугаар зүйлийн 65.1, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа компанийн хурлын зар хүргэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2022 оны 4 сарын 30-ны өдрийн 14 цагт Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд мэдээлэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Апп (Ard App) болон цаасан хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэхээр зохион байгуулсугай.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2022 оны 4 сарын 4-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлын даргаар Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг, дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр тус тус томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Баярбат

Хуульч Э.Оюун-Эрдэнэ

Хүний нөөц Г.Солонго

Маркетингийн менежер Н.Хандмаа

Мэдээлэл технологийн инженер Н.Бямбасүрэн

Дотоод аудитор П.Бямбасүрэн

Нярав Л.Насанбуян

6. Хурлын тооллогын комиссоор Г.Алтансүх (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)-ийг сонгон ажиллуулсугай.
7. Хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар саналаа урьдчилан ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцож, саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2021 оны 4 сарын 29-ний өдрийн 15 цаг 00 минут байхаар тогтоосугай.
8. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа компанийн хурлын зар хүргэх журмын дагуу Хурлын мэдэгдлийг Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах боломж, нөхцлөөр хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Г.Баярбат/-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 сарын 16-ны
өдрийн 02/22 тоот тогтоолын Хавсралт №1

**2022 ОНЫ 4 САРЫН 30-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 сарын 16-ны өдрийн 02/22 тоот тогтоолын Хавсралт №2

**САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2022 оны 4 сарын 30-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Саналын томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

- Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол компанийн байранд ирэх эсвэл www.arddaatgal.mn вэб сайтаас хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2022 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ (.....)

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 сарын 16-ны өдрийн 02/22 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг: 2022 оны 4 сарын 30-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхимд хуралд оролцох боломжтой бөгөөд мөн Ард Апп (Ard App) ашиглан хуралд саналаа өгөх боломжтой.

Компанийн оноосон нэр: Ард Даатгал ХК

Хурлын хэлэлцэх асуудал:

1. 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;

Бүртгэлийн өдөр: 2022 оны 4 сарын 4-ний өдөр

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4. 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2022 оны 3 сарын 31-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.arddaatgal.mn цахим хуудсаар зочлон хурлын материалтай танилцах боломжтой.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305-1307 тоот

Утас: 7720-0088 (Оператер)

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 сарын 16-ны
өдрийн 02/22 тоот тогтоолын Хавсралт №4

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	Ард Даатгал ХК
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305-1307 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 14 цаг 00 минут
Хурал хуралдах газар /хаяг байршил/:	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхимд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2022 оны 3 сарын 16-ны өдөр
Олон нийтэд заралсан огноо:	2022 оны 3 сарын 18-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2022 оны 4 сарын 4-ний өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, диллерийн компанид хүргүүлэх огноо:	2022 оны 3 сарын 23-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2022 оны 3 сарын 18-ны өдөр
Хурлын дарга:	ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс:	Тооллогын комиссын дарга: Г.Алтансүх Тооллогын комиссын гишүүд: Б.Ариунзул Р.Тогтохбаатар
Баримт бичгийн жагсаалт:	Хавсралтаар
Баримт бичгийн хуудасны тоо: хуудас

Хурал зохион байгуулах комиссын дарга



/Г. Цогбадрах/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

- | | |
|---|--------------------|
| <p>▲ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх
(ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг)</p> <ul style="list-style-type: none"> ▲ Хурлын ирц танилцуулах (Тооллогын комисс) ▲ Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах | 14:00-14:20 |
| <p>▲ Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх</p> <ul style="list-style-type: none"> ▲ 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
(Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах) ▲ 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
(ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр) ▲ 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
(ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг) | 14:20-15:00 |
| <p>▲ Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт</p> | 15:00-15:20 |
| <p>▲ Санал авах</p> | 15:20-15:35 |
| <p>▲ Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах</p> | 15:35-15:50 |
| <p>▲ Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах
(ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг)</p> | 15:50-16:00 |

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг 00 минут
Жич: Шаардлагатай тохиолдолд хурлын хугацааг сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай.

ТҮҮХЭН ТОВЧООН

- 2021 • Даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулав.
- 2021 • Хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж, 10,151 болов.
- 2020 • Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст 3 жил дараалан багтав.
- 2020 • Сэргээгдэх эрчим хүч болон уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүдэд даатгагчаар оролцож байна.
- 2019 • Ард Койн урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.
- 2018 • Ард Апп-д даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.
- 2018 • IPO гаргаж нээлттэй хувьцаат компани болов.
- 2017 • Газар тариалангийн даатгал хэрэгжүүлж эхлэв.
- 2017 • MSH International олон улсын эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлж эхлэв.
- 2016 • Давхар даатгалын ТРИТИ гэрээг байгуулав.
- 2016 • МҮХАҮТ-ын Оны Шилдэг Даатгалын компаниар 3 жил дараалан шалгарав.
- 2016 • Малын Индексжүүлсэн Даатгалын үйлчилгээ үзүүлж эхлэв.
- 2015 • Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулагч болов.
- 2014 • Татварын Ерөнхий Газрын дээд шагнал Хөх дэвтэр шагнал гардав.
- 2013 • МҮХАҮТ-ын Оны Шилдэг Даатгалын компаниар 3 жил дараалан шалгарав.
- 2012 • Гранд экспо-ийн Оны Шилдэг Даатгалын компани болов.
- 2011 • Оюу толгой төслийн бүтээн байгуулалтад оролцож эхлэв.
- 2011 • Гранд Даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэв.
- 2010 • Агаарын хөлгийн даатгалын үйлчилгээ нэвтрүүлэв.
- 2010 • International Quality Era Award (Switzerland, Geneva) шагнал гардав.
- 2008 • Санхүүгийн Зохицуулах Хорооны Оны Шилдэг Даатгалын компаниар шалгарав.
- 2004 • Их Британийн Omni Whittington Group хөрөнгө оруулагч болов.
- 2000 • Монгол Улсын ТОП-5 даатгалын компанийн нэг болов.
- 1994 • Анхны хувийн даатгалын компани болов.
- 1994 • Ард Даатгал ХК үүсгэн байгуулагдав.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- А Монгол улсын уул уурхай, барилга, сэргээгдэх эрчим хүчний салбарын даатгалын томоохон тоглогч болов.
- А Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индексэд дөрвөн жил дараалан багтав.
- А Мэдээлэл, бүртгэлийн үндсэн систем, харилцагчийн үйлчилгээний систем (call center), харилцагчийн менежментийн систем (CRM) зэргийн уялдааг ханган, шаардлагатай тохиолдолд цахимаар ажиллах бүрэн боломжтой болсон ба мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
- А Монгол улсад анх удаа Хүнд өвчний даатгал-ын шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлээ.
- А Нийт 6 жил, нээлттэй хувьцаат компани болсноос хойш 3 дахь жилдээ дараалан хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилав.
- А “Осолгүй, манлай жолооч” хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жил осол, аваар гаргаагүй хариуцлагатай даатгуулагчидаа АрдКойны урамшуулал олгов.
- А Цахим даатгалын шийдлийг хэвшил болгон утсаар, цахимаар, Ард Апп-аар даатгалын үйлчилгээг авах бүрэн боломжтой ажиллаж байна.
- А Гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монголчуудыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлж буй Хоум Моргейж Корпорэйшн ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан гадаадаас орон сууц худалдан авч байгаа иргэдэд орон сууцны зээлийн даатгалын үйлчилгээ үзүүлж эхлэв.
- А ДАН системтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, вэб хөгжүүлэлт болон Ард Апп дээр нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- А 2021 оны байдлаар нийт 10,151 гаруй иргэн, аж ахуйн нэгж тус компанийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд оны эхнээс 8,024 хувьцаа эзэмшигчээр буюу 4 дахин нэмэгдэж, бидэнд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл өндөр байсаар байна.
- А Ард Даатгал ХК нь жил бүр хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тарааж байгаа бөгөөд 2021 оны хувьд ч нэгж хувьцаандаа 40 төгрөг, нийт 1 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ олголоо.

Санхүүгийн байдлын тайлан

мянган төгрөг

ХӨРӨНГӨ	2021 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	983,099.63	1,176,593.74
Даатгалын авлага	3,567,406.41	2,144,556.64
Бусад санхүүгийн хөрөнгө	1,712,439.99	693,824.41
Бусад санхүүгийн бус хөрөнгө	946,715.21	921,909.63
Хөрөнгө оруулалт	23,609,897.85	18,009,391.76
Даатгалын хөрөнгө	1,924,246.94	3,401,296.12
Үндсэн хөрөнгө	2,082,238.10	2,428,893.26
Биет бус хөрөнгө		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,826,044.12	28,776,465.56

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2021 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Даатгалын өглөг	2,265,356.15	3,142,937.16
Бусад санхүүгийн өр төлбөр	941,160.07	1,151,113.28
Бусад санхүүгийн бус өр төлбөр	1,515,331.80	372,405.50
Орлогдод тооцоогүй хураамжийн нөөц	8,306,999.56	7,690,099.87
Нөөц сан	3,401,349.58	3,120,926.84
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	16,430,197.15	15,477,482.65
Эзэмшигчдийн өмч	5,000,000.00	5,000,000.00
Нэмж төлөгдсөн капитал	3,280,854.47	3,280,854.47
Хуримтлагдсан ашиг, алдагдал	10,114,992.50	5,018,128.43
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,395,846.97	13,298,982.90
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	34,826,044.12	28,776,465.56

Орлого үр дүнгийн тайлан

мянган төгрөг

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	2021 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Даатгалын хураамжийн нийт орлого	16,462,353.00	15,713,524.66
Даатгалын хураамжийн буцаалт	(570,234.50)	(201,559.73)
Давхар даатгалын хураамжийн зардал	(2,398,879.74)	(4,386,090.29)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	13,493,238.77	11,125,874.64
Орлогод тооцсон хураамж	11,692,708.32	9,693,703.40
Нийт нөхөн төлбөрийн зардал	(4,966,724.48)	(4,718,693.77)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	336,403.42	547,322.70
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	481,602.75	503,943.36
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(4,148,718.31)	(3,667,427.71)
Даатгалын гэрээний зардал	(2,153,742.85)	(1,810,430.10)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	178,126.94	131,275.74
Хөрөнгө оруулалтын олз, гарз	9,294,759.27	2,515,906.18
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)	14,185,017.72	7,064,166.95
Хүү, Эрхийн шимтгэлийн орлого	370.01	45,009.24
Бусад орлого	153,226.78	197,753.91
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,079,966.88)	(1,809,879.33)
Борлуулалт, маркетингийн зардал	(3,532,465.23)	(2,451,983.17)
Санхүүгийн зардал	(41,589.94)	(22,499.51)
Бусад зардал	(465,275.67)	(618,014.12)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,334.11	(30,852.56)
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	98,257.14	837.02
Бусад ашиг (алдагдал)	(5,863,109.68)	(4,689,628.53)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	8,321,908.04	2,374,538.42
Орлогын албан татварын зардал	(1,145,927.63)	(226,737.03)
Татварын дараах ашиг (алдагдал)	7,175,980.40	2,147,801.39
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Орлогын нийт дүн	7,175,980.40	2,147,801.39
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	287.04	85.91

2021 ОНД ОЛГОСОН НОГДОЛ АШГИЙН ТАЙЛАН

Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 10-ны өдрийн №1/21 тоот тогтоолын дагуу компанийн 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 40 төгрөг буюу цэвэр ашгийн 48.15 хувь болох нийт 1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.

Компанийн зарласан ногдол ашгийг 2021 оны 7 сарын 2-ны өдөр “Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-тай ногдол ашиг зуучлуулан тараалгах гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлсэн.

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч, даатгуулагчид болон хамтран зүтгэгчид та бүхэнд компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж байна.

2021 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улс орны эдийн засгийн байдал хүндэрч, тааварлашгүй нөхцөл байдал, бизнесийн үйл ажиллагаа, зах зээл эрс хумигдсан хүнд хэцүү байсан хэдий ч Ард Даатгал ХК-ийн хувьд энэ цаг үеийг амжилттай даван туулж ололт, амжилтаар дүүрэн, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг дааж, түүхэн амжилтууд гаргаж 2021 оны эцэст тавьсан зорилгодоо хүрч хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлсэн амжилттайгаар тайлант жилийг өндөрлүүлж байгаад баяртай байна.

Бид хувьцаа эзэмшигчдэдээ сүүлийн арав гаруй жилийн хугацаанд ногдол ашиг олгож ирсэн бөгөөд 2021 онд нэгж хувьцаанд 40 төгрөг, нийт 1 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хуваарилсны дагуу ҮЦТХТ-тэй гэрээ байгуулан 2021 оны 7 сарын 2-ны өдөр үнэт цаасны дансаар нь дамжуулан олгосон байна. 2021 оны 4 сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар зохион байгуулж тус хурлаар 2020 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулж, санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох зэрэг чухал асуудлууд хэлэлцэж шийдвэрүүдийг гаргасан байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 10,151 иргэн, аж ахуйн нэгж тус компанийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд оны эхнээс 8,082 хувьцаа эзэмшигчээр буюу 5 дахин нэмэгдэж, бидэнд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл өндөр байгааг дуулгахад таатай байна. Мөн тайлант жилд 9.4 сая ширхэг хувьцаа эргэлтэнд орж, нийт 11.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэн Монголын Хөрөнгийн Бирж дээрх хамгийн хөрвөх чадвар сайтай хувьцаануудын нэг байсаар байна. Хувьцааны үнийн хувьд тайлант жилд 705-1,800 төгрөгийн хооронд хэлбэлзэж, жилийн эцэст 1,319 төгрөгийн үнэтэй хаагдснаар өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад 65 хувиар өсч компанийн зах зээлийн үнэлгээ 33 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2021 онд Ард Даатгал компанийн хувьд нийт хөрөнгө 34.8 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс даруй 21 хувиар, өөрийн хөрөнгө 18.4 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 38 хувиар тус тус өссөн байна. Мөн 16.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэн, 5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 3,000 гаруй даатгуулагч нарт олгосон байна. Даатгалын компанийн үндсэн орлогоос гадна ашгийг бүрдүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг хөрөнгө оруулалтын багц 25.1 тэрбум төгрөгт, хөрөнгө оруулалтын орлого 9.3 тэрбум төгрөгт хүрснээр 7.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Ковид-19 цар тахлын үед, түүнчлэн хөл хорионы үед ажилласан төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын ажиллагсдад зориулж Ковид-19 өвчний эрсдэлээс хамгаалсан “Ковидын даатгалын” бүтээгдэхүүн шинээр зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд тус даатгалаар нийт 400 гаруй сая төгрөгийн нөхөн олговор олгон даатгуулагчдад санхүүгийн бодит туслалцаа үзүүлэн ажилласан байна.

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг хийж, компанийн Гүйцэтгэх захиралд бүрэн итгэл хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд ТУЗ-ийн зүгээс бүх талаар дэмжин ажиллах болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 он 4 сар 30 өдөр

№1/22

Улаанбаатар хот

2021 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ... тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ч.ГАНХУЯГ

Хүчтэй. Хамтдаа.